**“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК**
Утас: 99359854, 99055703, 99058176
Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com
Шуудангийн хайрцаг: 444

2025.01.28 № А/04

Танай _____ -ний/ны № _____ -д

“БИДЭТ ББСБ” ХХК-ИЙН УДИРДЛАГАД

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Бидэт ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Бидэт ББСБ” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31 -ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

### Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс оор сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад оршдог. Ул үндэслэлтэй нотолгоо нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг цаг ямагт илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй.

МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба дангаараа юм уу нийлээд материаллаг болж эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталдаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдсэн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус, тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгааг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарлаа хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөхийг шаардлагатай болдог. Аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулга багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

### Бусад асуудал

Энэхүү тайланг өөр ямар нэг зорилгоор биш, компанийн хувьцаа эзэмшигчид, засаглах эрх бүхий удирдлагын багт зориулан гаргасан бөгөөд бусад этгээдэд зориулагдаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ЗАХИРАЛ Б.БАЙГАЛ

ОРХОН АЙМАГ МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ ХХК 6108271333 4408292

МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ

## 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| | Үзүүлэлт | 2023 төгрөг | 2024 төгрөг |
|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | | |
| | 1.1 Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 1,352,806,984.15 | 832,105,232.65 |
| | 1.2 Зээл | 1,769,905,430.87 | 2,474,761,025.72 |
| | 1.3 Факторингийн тооцооны авлага | 25,022,602.17 | - |
| | 1.4 Үүсмэл санхүүгийн хөрөнгө | - | - |
| | 1.5 Хөрөнгө оруулалт | - | - |
| | 1.6 Бусад санхүүгийн хөрөнгө | - | - |
| | 1.7 ***Санхүүгийн хөрөнгийн дүн*** | *3,147,735,017.19* | *3,306,866,258.37* |
| | 1.8 ААНОАТ-ын авлага | | 37,034,623.45 |
| | 1.9 Үндсэн хөрөнгө | 204,372,963.76 | 207,775,778.42 |
| | 1.10 Биет бус хөрөнгө | 1,053,433.34 | 254,008.34 |
| | 1.11 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | - |
| | 1.12 Бусад санхүүгийн бус хөрөнгө | - | 165,500,000.00 |
| | 1.13 ***Санхүүгийн бус хөрөнгийн дүн*** | *205,426,397.10* | *410,564,410.21* |
| 1.14 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,353,161,414.29** | **3,717,430,668.58** |
| 2 | **Өр төлбөр** | | |
| | 2.1 Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр | - | - |
| | 2.2 Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | - | - |
| | 2.3 Бусад эх үүсвэр | - | - |
| | 2.4 Үүсмэл санхүүгийн өр төлбөр | - | - |
| | 2.5 Бусад санхүүгийн өр төлбөр | - | 7,241,469.07 |
| | 2.6 Хоёрдогч өглөг | - | - |
| | 2.7 Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр) | | |
| | 2.8 ***Санхүүгийн өр төлбөрийн дүн*** | - | 7,241,469.07 |
| | 2.9 Татвар, НДШ-ийн өр тбөлбөр | 10,089,044.86 | 36,808,341.56 |
| | 2.10 Нөөц /Болзошгүй өр төлбөр/ | - | - |
| | 2.11 Хойшлогдсон татварын өр | - | - |
| | 2.12 Бусад санхүүгийн бус өр төлбөр | - | - |
| | 2.13 ***Санхүүгийн бус өр төлбөрийн дүн*** | *10,089,044.86* | *36,808,341.56* |
| 2.14 | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | *10,089,044.86* | *44,049,810.63* |
| 3 | **Өмч** | | |
| | **3.1** Хувь нийүүлсэн хөрөнгө | 3,266,000,000.00 | 3,266,000,000.00 |
| | **3.2** Өмчийн бусад хэсэг | - | - |
| | **3.3** Хуримтлагдсан ашиг (алдагдал) | *77,072,369.43* | *407,380,857.95* |
| 3.4 | НИЙТ ӨМЧИЙН ДҮН | *3,343,072,369.43* | *3,673,380,857.95* |
| 3.5 | **ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН** | **3,353,161,414.29** | **3,717,430,668.58** |



МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ

## 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

| | Үзүүлэлт | 2023 төгрөг | 2024 төгрөг |
|---|---|---|---|
| **1** | **Хүүгийн орлого** | - | - |
| 1.1 | Банканд байршуулсан хөрөнгийн | 5,153,466.74 | 5,950,486.59 |
| 1.2 | Санхүүгийн байгуулагад байршуулсан хөрөнгийн | - | - |
| 1.3 | Зээлийн | 341,760,384.39 | 678,000,774.17 |
| 1.4 | Үнэт цаасны | - | - |
| 1.5 | Бусад | - | 12,982,185.77 |
| 1.6 | (Хүүгийн орлогын буцаалт) | - 33,131,514.37 | - |
| **1.7** | ***Хүүгийн орлогын дүн*** | **313,782,336.76** | **696,933,446.53** |
| **2** | **Хүүгийн зардал** | | |
| 2.1 | Итгэлцлийн үр шим | - | - |
| 2.2 | Зээлийн | - | - |
| 2.3 | Үнэт цаасны | - | - |
| 2.4 | Бусад | - | - |
| 2.5 | (Хүүгийн зардлын буцаалт) | - | - |
| **2.6** | ***Хүүгийн зардлын дүн*** | - | - |
| **3** | **Хүүгийн цэвэр орлого (1.7-2.6)** | **313,782,336.76** | **696,933,446.53** |
| **4** | Эрсдэлийн сангийн зардал | 93,875,167.41 | 50,000,000.00 |
| **5** | **Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого (3-4)** | **219,907,169.35** | **646,933,446.53** |
| **6** | **Бусад орлого** | **18,773,250.00** | **32,528,999.96** |
| 6.1 | Хүүгийн бус орлого | 18,773,250.00 | 32,528,999.96 |
| 6.2 | Бусад орлого,олз | | |
| **7** | **Бусад зардал** | **153,066,185.17** | **267,966,630.38** |
| 7.1 | Хүүгийн бус зардал | 153,066,185.17 | 259,312,770.38 |
| 7.2 | Бусад зардал, гарз | | 8,653,860.00 |
| **8** | **Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)** | **85,614,234.18** | **411,495,816.11** |
| **9** | **Орлогын татварын зардал** | 8,567,423.41 | 4,114,958.16 |
| **10** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **77,046,810.77** | **407,380,857.95** |
| **11** | Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал | - | - |
| **12** | **Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал ( 10+11)** | **77,046,810.77** | **407,380,857.95** |
| **13** | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| **14** | **Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)** | **77,046,810.77** | **407,380,857.95** |



МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ